



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 1/72

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх  
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон Хаягжуулалтын тухай хуулийн дагуу шинэ хаяг авсан 1 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Ж.Өлзийжаргал)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны 172 дүгээр захирамжийн хавсралтын 10 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010241

Дундговь аймгийн Засаг даргын 2020 оны 23 дугаар сарын 16 ны  
 өдрийн 11 дугаар захирамжийн хавсралт



№	Өмчлөгчийн		Өмнөх захирамжийн		Өмнөх газрын		Газрын			
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Огноо дугаар	Холбогдох хэсгийн дугаар	Байршил	Хэмжээ /м2/	Хэмжээ /м2/	Хэмжээ /м2/	Байршил
1	Дангажав	Анхбаяр	3Ю93092635			Нарлаг 6-6	600	702	Нарлаг 3-318	2808000